



БҮГД НАЙРАМДАХ АВСТРИ УЛСЫН ШҮҮХИЙН ШИЙДВЭРИЙН ХУРААНГУЙ

(Захиргааны эрх зүйн маргаан)¹

ЦАГДААГИЙН АЛБАН ХААГЧИЙН ДҮРЭМТ ХУВЦСАА ӨМСӨХ, АЛБАНЫ ХЭРЭГСЛЭЭ БЭЛТГЭХ ЦАГ ХУГАЦААГ АЖЛЫН ЦАГТ ТООЦНО

САНАМЖ: Энэхүү хураангуй нь хуульч, судлаач, эрх зүйн чиглэлээр суралцагчдад болон олон нийтэд мэдээлэл өгөх зорилготой бөгөөд хураангуйд ашигласан шийдвэр нь гадаад улсын шүүхийн шийдвэр болно.

Шүүхийн шийдвэрийн дугаар: Ro 2023/12/0057-8, Landespolizeidirektion Wien (хариуцагч: Вена хотын Цагдаагийн газар) v Beschwerdeführer Wasserpolizei A (гомдол гаргагч: Усан замын цагдаагийн албан хаагч “А” нэрийг шүүхийн шийдвэрт нууцалсан).

Шүүхийн шийдвэрийн огноо: 2025 оны 9 дүгээр сарын 15 өдөр

ХЭРГИЙН ТУХАЙ ТОВЧ

Гомдол гаргагч А нь Вена хотын Цагдаагийн газрын харьяа Усан замын цагдаагийн хэлтэст ажиллаж байгаад 2022 оны 10 дугаар сарын 01-ний өдөр тэтгэвэрт гарсан байна. Усан замын цагдаагийн хэлтсийн онцлогоос шалтгаалан гомдол гаргагч А нь өдөр бүр ажлын байран дээрээ дүрэмт хувцсаа өмсөж, хамгаалалтын хантааз, албаны хэрэгслээ авч бэлтгэдэг, мөн ээлж дууссаны дараа эдгээр хэрэгслээ буцаан хураалгаж, дүрэмт хувцсаа сольдог байжээ.

Харин Вена хотын Цагдаагийн газар энэхүү дүрэмт хувцас өмсөж, тайлах, албаны хэрэгслээ бэлтгэх хугацааг ажлын цагт оруулан тооцдоггүй байсан учраас гомдол гаргагчийн зүгээс 2021 оны 12 дугаар сарын 08-ны өдөр Вена хотын Цагдаагийн газарт хандан дүрэмт хувцас солих, албаны хэрэгслээ авч бэлтгэх хугацааг ажлын цагт оруулан тооцож, илүү ажилласан цагийн хөлсөө нөхөн олгуулахаар гомдол гаргасан байна.

Вена хотын Цагдаагийн газраас “дүрэмт хувцас өмсөх, тайлах, албаны хэрэгслийг бэлтгэх хугацааг ажлын цагт тооцох хууль зүйн үндэслэл байхгүй, мөн цагдаагийн албан хаагчдад олгогддог тусгай нэмэгдэл цалин болон эрсдэлийн нэмэгдэл нь энэ төрлийн үйл ажиллагаанд зориулагдсан болно” гэж тайлбарлаад, гомдлыг хангахаас татгалзаж шийдвэрлэжээ.

Иймд гомдол гаргагч А-ын зүгээс Холбооны захиргааны шүүхэд Вена хотын Цагдаагийн газрын гомдлыг татгалзаж шийдвэрлэснийг хүчингүй болгуулах, өөрт олгогдох ажлын цагийн хөлсийг нөхөн төлүүлэх тухай нэхэмжлэлийн шаардлагыг гаргасан байна.

ХУУЛЬ ХЭРЭГЛЭЭ, ШҮҮХИЙН ШИЙДВЭР

Анхан шатны шүүхээс: Цагдаагийн албан хаагчийн дүрэмт хувцсаа өмсөх, тайлах, албаны хэрэгслээ бэлтгэх хугацаанд холбогдох цалин хөлс нь 1979 оны

¹ Шүүхийн шийдвэрийг бүрэн эхээр үзэх холбоос: https://www.vwgh.gv.at/rechtsprechung/aktuelle_entscheidungen/ro2023120057.html, шийдвэрийг хураангуйлахдаа эх хувилбарын бүтцийг өөрчилсөн болно.



Цалин хөлсний тухай хуулийн² 81 дүгээр зүйл (Цагдаагийн албаны нэмэгдэл), 82 дугаар зүйлд (Онцгой аюулын нөхөн олговор) заасан нэмэгдлүүдээр нөхөн олгогдсон, мөн гомдол гаргагч А-ын гомдлын үндэслэл болгосон Европын парламент болон зөвлөлийн 2003 оны 11 дүгээр сарын 04-ний өдрийн “Ажлын цагийн зохион байгуулалтын зарим асуудлын тухай” (RL 2003/88/EC)³ удирдамжаар албан хаагчийн ажлын цаг, нөхөн олговрын асуудлыг зохицуулаагүй гэж үзээд гомдлыг хангахаас татгалзаж шийдвэрлэжээ.

Гомдол гаргагч А давж заалдах гомдолдоо: “Холбооны захиргааны шүүх Европын холбооны эрх зүйн баримт бичгийг буруу тайлбарласан, учир нь Европын Холбооны шүүхийн практик болон RL 2003/88/EC удирдамжид ажилтан ажил олгогчийн заавар, шаардлагын дагуу тодорхой үйл ажиллагаа явуулж, албан үүргээ гүйцэтгэх, зайлшгүй шаардлагаар бэлтгэх ажиллагаа хийж байгаа хугацааг ажлын цагт хамаарах боломжтой талаар дурдсан” гэсэн үндэслэлээр давж заалдах гомдол гаргажээ.

Давж заалдах шатны шүүх (Захиргааны дээд шүүх)⁴-ээс: Европын парламент болон зөвлөлийн 2003 оны 11 дүгээр сарын 04-ний өдрийн “Ажлын цагийн зохион байгуулалтын зарим асуудлын тухай” (RL 2003/88/EC) удирдамжид заасны дагуу шийдвэрлэсэн Европын холбооны шүүхийн “Тусо”, “Matzak”-д холбогдох хэргүүдийг эш татсан бөгөөд ажил дээр өнгөрүүлэх цаг хугацаа нь ажлын цаг эсхүл амралтын цагийн аль нэгэнд хамаарах ёстой гэж үзжээ.

Захиргааны дээд шүүхээс аливаа үйл ажиллагааг дараах 3 урьдчилсан нөхцөл зэрэг хангагдсан нөхцөлд ажлын цагт тооцно гэжээ. Үүнд (1) ажилтан нь өөрийн албан үүрэгт холбогдох байршилд байх, (2) ажил олгогчийн заавар, мэдэлд байх, (3) ажил үүргээ гүйцэтгэж байх буюу ажил үүргээ гүйцэтгэхэд шаардагдах үйл ажиллагаа явуулж байх гэж тодорхойлсон байна. Иймд гомдол гаргагч А-ын **дүрэмт хувцас өмсөх, тайлах, албаны хэрэгслээ бэлтгэх цаг хугацаа нь ажлын цагт тооцогдож болно**. Холбооны захиргааны шүүх бодит нөхцөл байдлыг тогтоож, шалгаагүй байна гэжээ.

Мөн Цалин хөлсний тухай хуулийн 81 дүгээр зүйлд заасан зохицуулалт нь цагдаагийн ажлын онцгой ачаалал, эрсдэлд зориулагдсан нэмэгдэл, харин 82 дугаар зүйлд заасан зохицуулалт нь онцгой аюултай нөхцөл байдлын үеэр ажилласанд зориулж олгодог нэмэгдэл болохоос ажлын цагийн хөлс биш гэж тайлбарлажээ. Иймд Захиргааны дээд шүүхээс Холбооны захиргааны шүүхийн шийдвэрийг хүчингүй болгож шийдвэрлэсэн байна.

² Gehaltsgesetz, GehG, 1956,

<https://www.ris.bka.gv.at/geltendefassung.wxe?abfrage=bundesnormen&gesetzesnummer=10008163>, (Сүүлд үзсэн: 2026.06.18).

³ The European Parliament and of the Council, 04.11.2003, 2003/88/EC, Concerning certain aspects of the organisation of working time, <https://eur-lex.europa.eu/legal-content/EN/TXT/?uri=CELEX%3A32003L0088>, (Сүүлд үзсэн: 2026.06.18).

⁴ Австри улсын захиргааны хэргийн шүүхийн системийн хувьд давж заалдах шатанд Австри Улсын Захиргааны дээд шүүх эцсийн шийдвэрийг гаргадаг ба Холбооны хуулиар харьяалуулсан Холбооны захиргааны шүүх болон бүс нутгийн 9 захиргааны шүүх анхан шатны хүрээнд шийдвэр гаргадаг. The Austrian Judicial System, https://www.justiz.gv.at/file/8ab4ac8322985dd501229d51f74800f7.de.0/cover_und%20text_the%20austrian%20judicial%20system_neu.pdf?forcedownload=true, (Сүүлд үзсэн: 2026.06.18).